



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар A/32

Чойр

Аймгийг хөгжүүлэх таван жилийн  
үндсэн чиглэл, Засаг даргын 2024-2028  
оны үйл ажиллагааны хөтөлбөрийг  
оловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 60 дугаар зүйлийн 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.1, 17 дугаар зүйлийн 17.2, Засгийн газрын 2022 оны 470 дугаар зүйлийн 1.1, 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бодлогын баримт бичгүүд “Аймгийн 2025-2023 оны таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г тус тус боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Содном

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Т.Бат-Эрдэнэ

(Сүмбэр сумын Засаг дарга)

Б.Ганбаяр

(Баянтал сумын Засаг дарга)

Ч.Сугармаа

(Шивээговь сумын Засаг дарга)

Б.Нэргүйцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Ц.Отгончимэг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Төрийн захиргааны удирдлагын  
хэлтсийн дарга)

Г.Хонгор

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн дарга)

Т.Баясгалан

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

М.Анхбаяр

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хяналт шинжилгээ, үнэлгээний  
хэлтсийн дарга)

А.Отгонтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн  
дарга)

Ц.Нацагдорж

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Цэргийн штабын дарга, хурандаа)

Д.Мөнх-Эрдэнэ

(Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын дарга)

Э.Түвшинзаяа

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Отгончимэг

(Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын дарга)

Б.Зургаанжин

(Боловсрол, шинжлэх ухааны газрын  
дарга)

Б.Энхтөр

(Соёл урлагийн газрын дарга)

Ц.Мөнх-Од


(Эрүүл мэндийн газрын дарга)

Х.Буянбаяр

(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
газрын дарга)

2. Бодлогын баримт бичгүүдийг холбогдох хууль, журмын дагуу олон нийтийн эрх ашигт нийцүүлэн, урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн залгамж чанарыг хадгалан, уялдуулж, судалгаа шинжилгээ, орон нутгийн нөөц бололцоонд үндэслэн, иргэд олон нийтээр хэлэлцүүлж, оновчтой, үр ашигтай, бодитой төлөвлөн, 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн дотор боловсруулж аймгийн Иргэдийн төлөөөлөгчдийн хуралд өргөн барихыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ